- Бараа материалын дансны үлдэгдэл 139,766.5 мянган төгрөгт хүрч 51,168.8 мянган төгрөгөөр өссөн нь 40,956.5 мянган төгрөгийн үнэт цаас хэвлүүлснээс;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 722.1 мянган төгрөгт хүрч 25,887.7 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагад төлөх өр төлбөрийг барагдуулснаас тус тус шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,810,170.3 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 45.8 хувиар бууруулж 2,607,316.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс цалин хөлс, НДШ-ийн 908,766.64 мянган, томилолт, зочны зардлын 203,668.0 мянган, бараа үйлчилгээний зардлыг 508,129.5 мянган, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөрийн 488,810.3 мянган, бусад зардлын 93,479.7 мянган төгрөгийг тус тус бууруулж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд баталсан төсвийг 200,822.3 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар нэмэгдүүлж нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,808,138.7 мянган төгрөг болгон тодотгосон байна. Үүнд цалин хөлс, НДШ-ийг 23,011.1 мянган, эд хогшил, ургал засварын зардлыг 123,605.0 мянган, томилолт, зочны зардлыг 40,000.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардлыг 16,545.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн бол бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөрийг 30,510.2 мянган, байр ашиглалттай холбоотой зардлыг 2,482.3 мянган төгрөгөөр тус тус бууруулан тодотгосон байна.

Төсвийн гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангийн төсвөөс 2,638,138.7 мянган төгрөгийн санхүүжилтийг, туслах үйл ажиллагааны орлогоос 108,270.3 мянган төгрөгийг, нийт 2,746,409.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,632,657.0 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 83,636.9 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг нийгмийн даатгалын санд, 37,584.9 мянган төгрөгийг ТӨБЗГ-т төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71901	Нийгмийн даатгал	2,808,138.7	2,632,657.0	175,481.7	93.8%
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,361,042.8	2,202,225.2	158,817.5	93.3%
80103	Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээ	59,930.0	56,790.0	3,140.0	94.8%
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	61,200.0	60,925.1	274.9	99.6%
80213	Өмгөөлөл, хуулийн зөвлөх үйлчилгээ	1,000.0	237.8	762.2	23.8%
80219	Харуул, хамгаалалтын зардал	39,510.0	38,100.0	1,410.0	96.4%
80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	143,050.0	133,853.2	9,196.8	93.6%
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	76,551.6	74,671.4	1,880.2	97.5%
80813	Хуульд заасан үндэслэлээр алба	11,000.0	11,000.0	-	100%
80820	Бусад тусламж, дэмжлэг	54,854.3	54,854.2	0.1	99.9%

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын санхүүгийн программын хөгжүүлэлтийг хангуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, туслах үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөж, батлуулах, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулж ажиллах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг СНАГ-ын ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, аудитор А.Баясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ч.Болд, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/185 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 2,864,337.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 28,613.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоо шаардлагатай гэж үзэн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 3,150,977.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 31,509.8 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой хоёр дэд даргыг албан ўргээс нь чөлөөлсөн, суудлын автомашиныг хот дотор ашиглаагүй, ажилтан, албан тушаалтууд гадаад албан томилтоор ажиллаагүй зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, баталсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

НДЕГ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-т заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгээс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 216,062.4 мянган төгрөгийн 1 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, 6.4.8-т заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 10,447.5 мянган төгрөгийн 6 тушаал, шийдвэрийг хугацаа хоцроож, 8 тушаал, шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8-д заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, цахим хуудсанд мэдээллийг тогоосон хугацаанд нь тогтмол шуурхай оруулж ажиллах албан шаардлага өгөх.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

НДЕГ нь 2006 оноос санхүү, нягтлан бодох бүртгэлд Sanhoo программыг ашиглаж байгаад 2022 оноос Green finance программыг нэвтрүүлж, санхүүгийн тайланг бэлтгэсэн боловч, ерөнхий болон мөнгөн гүйлгээний журналын мэдээллүүд бүрэн бус, үндсэн хөрөнгө, бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл, орлого, зарлагын журналын дүн зэрэг мэдээллүүд нь алдаатай татагдаж, аудитын явцад санхүүгийн мэдээллийг иж бүрнээр, тодорхой илэрхийлэхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуй нэгж байгууллага бүртгэлийн дараах зарчмыг баримтална, 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ын 1.3-д "журнал, ерөнхий данс, санхүүгийн тайланд тодруулга хийх боломжтой болон бүртгэлийн маягтууд нь стандартын шаардлагыг хангасан байх", 1.10-д "санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар дөхөмтэй мэдээллийн эх үүсвэрийг иж бүрнээр тодорхой харуулдаг байх", 2.2-д "мэдээлэл иж бүрэн, үнэн зөв байх", 3.7-д "үндсэн хөрөнгө дахин үнэлгээ, элэгдлийн бүртгэл", 3.10-д "биет бус хөрөнгийн бүртгэл" гэж заасантай бүрэн нийцээгүй, "толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн, нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийн ашиглалтыг бүрэн нэвтрүүлэх, хөгжүүлэлт хийлгэх, дээрх хууль, тогтоомжийн заалтад бүрэн нийцүүлэх, зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж өгөх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 654,447.4 мянган төгрөгийн 11 асуудлыг илрүүлж зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 412,221.5 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулсан байна. Биелэлт хангалтгүй 242,226.0 мянган төгрөгийн 3 зөрчлийг тайлант оны буруу илэрхийлэлд оруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 93.3 хувийн биелэлттэй байна.



Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	179.0	1	179.0	100.0
Албан шаардлага	3	1,712,957.0	3	1,712,957.0	100.0
Зөвлөмж	5	15,303.7	4	14,589.3	80.0
Нийт дүн	9	1,728,439.7	8	1,727,725.3	93.3

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар дараах асуудлыг анхаарах шаардлагатай гэж үзэн. Үүнд:

- ТӨБЗГ-ын шийдвэр хүлээгдэж байгаа шалтгаанаар данснаас хасаагүй эзэмших эрхгүй биетээр оршин байхгүй хөрөнгө бүртгэлтэй байгаа эсэх;
- Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бараа, ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болголгүй, нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн шууд худалдан авалт хийсэн бараа, ажил үйлчилгээ байгаа эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 136,855.9 мянган төгрөгийн алдааг аудитын явцад запруулж, алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн. Үүнд:

Дансны бичилт буруу хийсэн 135,245.3 мянган төгрөгийн 3 алдаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн системийн алдаанаас шалтгаалан тооцооллын зөрүү үүссэн 1,610.6 мянган төгрөгийн 1 алдаа гарсан байна.

Аудитаар нийт 184,298.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 105,512.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлж, 78,785.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Зардалтай холбоотой асуудал

НДЕГ-ын даргын 2020 оны А/30 дугаар тушаалаар нийт орон тоог 82 байхаар баталсан ба тайлант онд орон тоонд багтаагүй жолооч, үйлчилгээний 10 гэрээт ажилтныг ажиллуулсан байна. Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд 3 жолоочийг ажлаас чөлөөлж, 7 үйлчилгээний ажилтныг одоог хүртэл ажиллуулж, дээрх ажилтнуудын цалин, НДШ-д 92,783.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "баталсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг мөрдөж, баталсан орон тооны хязгаарт багтаан ажиллах албан шаардлага өгөх.

2. Зардалтай холбоотой асуудал

НДЕГ нь ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдож, ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-ийн зардлыг байгууллагын төсвөөс төлснийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлж, төрийг хохиролгүй болгох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5 заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон цалин, НДШ-ийн зардлыг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэн төрийг хохиролгүй болгох арга хэмжээ авч ажиллах албан шаардлага өгөх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын ерөнхий газар нь туслах үйл ажиллагааны орлогоор 2022 онд 170,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр баталсан бөгөөд туслах үйл ажиллагааны



орлогыг үндэслэлтэй төлөвлөж, хянуулаагүйгээс гүйцэтгэлээр орлого 73,701.2 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийг мөрдөж, туслах үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөх, зөрчлийг дахин гаргахгүй байх.

2. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

Илцуулэлт: НДЕГ-ын 2022 оны санхүүгийн тайланда авлага 4,432.5 мянган, өр төлбөр 722.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийг мөрдөх, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулах, зөрчлийг дахин гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй				
Санхүүгийн байдлын тайландаа бусад үндсэн хөрөнгийн хуримтлагдсан эзэгдлийг 1,610.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	1,610.6			1	1,610.6	1	1,610.6			1	1,610.6
Төнөрийн баримт бичиг борлуулсан орлогыг өглөгөөр бүртгэж, санхүүгийн үлдэгдлээр бүртгасэн.	1	875.0			1	875.0	1	875.0			1	875.0
Санхүүгийн үр дүнгийн тайландаа үндсан болон туслах үйл ажиллагааны орлогын 108,270.3 мянган төгрөгийн, нэмээлт санхүүжилтийн 26,100.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээний эдийн засгийн ангиллыг данс буруу бүртгэж тайлагнасан.	2	134,370.3			2	134,370.3	2	134,370.3			2	134,370.3
Дүн	4	136,855.9			4	136,855.9	4	136,855.9			4	136,855.9

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				
		Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж		
1	2022 оны санхүүгийн тайлангаар 4,432.5 мянган төгрөгийн авлага, 722.1 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлэлтэй байна.	1	5,084.6				1	
2	Туслах үйл ажиллагааны орлогоор 2022 онд 170,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр баталсан бөгөөд туслах үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөж, хянуулаагүйгээс гүйцэтгэлээр орлого 73,701.2 мянган төгрөгөөр тасарсан байна.	1	73,701.2				1	
3	НДЕГ-ын 2020 оны 03 дугаар сарын 20-ны А/ЗО тушаалаар нийт орон тоог 82 байхаар баталсан байна. Байгууллагын баталсан төсвийн хувваарьт орон тоо, зардлын төсөө батлагдаагүй байхад 10 гэрээт ажилтныг ажиллуулан 92,783.0 мянган төгрөгийн цалин, шимтгэл бодон олгосон байна.	1	92,783.0			1	92,783.0	
4	Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь Шүүхийн шийдвэрээр тогтоогдж, ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-ийн зардлыг байгууллагын төсвөөс төлснийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нехэн төлүүлж төрийг хохиролгүй болгох арга хэмжээг авч ажиллаагүй.	1	12,729.7			1	12,729.7	
Дүн		4	184,298.4			2	105,512.7	ТӨРЛИЙН АУДИТИН БАЙГУУЛАГА 78,785.7



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д/Д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зэвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1	Шилэн дансны нэгдсэн цахим системд 2022 оны жилийн эцсийн байдлаар дараах зөрчил илэрсэн. Үүнд: 1. Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-т заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 216,062.4 мянган төгрөгийн 1 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, 2. Шилэн дансны тухай хуулийн 6.4.8-т заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 8 тушаал, шийдвэрийг мэдээлээгүй, 10,447.5 мянган төгрөгийн 6 тушаал, шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	226,509.9			1	226,509.9		
2	НДЕГ нь 2006 оноос нягтлан бодох бүртгэлд Sanhui программыг ашиглаж байгаад 2022 оноос эхлэн Green finance программыг нэвтрүүлсэн байна. Гэвч тус программ нь ерөнхий болон мөнгөн гүйлгээний журналыг хөрөүүлахэд харилцагчийн мэдээлэл, харьцсан дансны мэдээллийг харуулдаггүй, бараа материалын орлого, зарлагын журналын дүн дэлгэрэнгүй бүртгэлийн дүнгээс зөрүүтэй, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд хөрөнгийн мэдээллийг дутуу илэрхийлэгддэг зэрэг алдаанууд аудитын явцад гарч байна.	1	-					1	-
Дүн		2	226,509.9			1	226,509.9	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 20 № 29/A0170467
Сনгт-2023/173/на-стя-тиз

Улаанбаатар хот

Г Зөрчил арилгах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2020 оны А/30 дугаар тушаалаад нийт орон тоог 82 байхаар баталсан ба тайлант онд орон тоонд багтаагүй жолооч, үйлчилгээний 10 гэрээт ажилтныг ажиллуулсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд 3 жолоочийг ажлаас чөлөөлж, 7 үйлчилгээний ажилтныг одоог хүртэл ажиллуулж, дээрх ажилтнуудын цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 92,782,973.35 төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Төсвийн тухай хуулийг мөрдөж, баталсан орон тооны хязгаарт багтаан ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Ахлах нягтлан бодогч П. Адъяасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Б.Р.* Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

Ч.БОЛД
А.Баясгалан

А.БАЯСГАЛАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-26/230

Z:\Alban Shaardлага\2023\0217\SNAG-37.Docx

0001080090



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 20 № 30/АО/70467
Санкт-2023/173/иа-СТА түз

Улаанбаатар хот

Г Зөрчил арилгах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдож, ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн 12,729,710.69 төгрөгийн зардлыг байгууллагын төсвөс төлснийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлж, төрийг хохиролгүй болгох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны A/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон цалин, НДШ-ийн зардлыг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэн төрийг хохиролгүй болгох арга хэмжээ авч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Ахлах нягтлан бодогч П. Адъяасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН: САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР АУДИТЫН МЕНЕЖЕР АУДИТОР		ЦНАРАНЧИМЭГ Ч.БОЛД А.БАЯСГАЛАН
---	--	---

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, I-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

C:\Alban Shaardлага\2023\02\17 SNAG-37.Docx

0001080094



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 20 № 31/A0170467
С НӨГ-2023/173/на-стя-тцз

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 216,062,400.0 төгрөгийн 1 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, 6.4.8-д заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 10,447,498.0 төгрөгийн 6 тушаал, шийдвэрийг хугацаа хоцроож, 8 тушаал, шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны A/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн аж тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

- Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, цахим хуудсанд мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол шуурхай оруулж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Ахлах нягтлан бодогч П. Адъяасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН: САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР АУДИТЫН МЕНЕЖЕР АУДИТОР	 Ч.НАРАНЧИМЭГ Ч.БОЛД А.БАЯСГАЛАН
---	--

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-26/30

Z:\Alban Shaardлага\2023\0217\SNAG-37.Docx



0001080096